



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/563

Номгон

Нэгдсэн эмнэлэгт Коронавируст халдвар
(КОВИД-19) илрүүлэх түргэвчилсэн оношлуурын
нөөц бүрдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дүгээр сарын 06-ний өдрийн 58 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Коронавируст халдвар (КОВИД-19)-ын түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлэх ажлыг яаралтай зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх оношлуурыг татан авч, нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Түргэвчилсэн оношлуурт шаардагдах 138.000.000 (Нэг зуун гучин найман сая) төгрөгийг Нэгдсэн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Нэгдсэн эмнэлэг (А.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

801210309

Аймгийн Засаг дарга 2021 оны 09 сарын 09-ны
өдрийн А.1563 дугаар захирамжийн хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТҮРГЭВЧИЛСЭН
ОНОШЛУУРЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуур	10000	13.800	138.000.000

оОо